# ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭЛЭЛ

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдан гарсан бөгөөд хуулийн гол зарчмын зохион байгуулалтын шинэчлэл нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан байгуулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулахад зөвхөн төрийн байгууллага хоорондтодийгүй төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн хүч, боломж, санал санаачлагыг өргөн хамруулан ажиллахаар болсон байна.

Үндэсний зөвлөл нь:

- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, хөтөлбөр, холбогдох дүрэм, журмын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг оновчтой болгоход чиглэсэн үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт дэвшил, дэвшилтэт техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар үүрэг, чиглэл өгөх, зөвлөмж гаргах, ажлын хэсэг байгуулах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, чиглэл өгөх, тайлан мэдээ гаргах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, захиргааны шийдвэр, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, шаардлага тавих;
- байгууллага, албан тушаалтнаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;
- иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцохыг сурталчлах, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр санамж, зөвлөгөө үнэ төлбөргүй нийтлэх, нэвтрүүлэх, түгээхийг үүрэг болгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэх юм.

Дээрх эрх, үүргийн дотор багтаж буй Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг хуулийн 10 дугаар зүйлд тодорхой зааж өгсөн бөгөөд энэхүү бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ. Үүнд:

- тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан /Автотээврийн үндэсний төв ТӨҮГ/-д механикжсан тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, ашиглалт, засвар, оношилгооны бүртгэл, мэдээллийг хамруулах;
- зам, замын байгууламжийн эвдрэл, гэмтлийн бүртгэл, мэдээллийн сан /Зам, тээврийн хөгжлийн төв/-д замын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй зам, замын байгууламжийн төлөв байдал, эвдрэл, гэмтлийн бүртгэл, мэдээллийг хамруулах;
- жолоочийн бүртгэл, мэдээллийн сан /Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл мэдээллийн төв/-д жолоодох эрхийн үнэмлэх дээрх мэдээллийн бүртгэл, мэдээллийг хамруулах;
- жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн сан /ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт/-д жолооч

бэлтгэх сургалтын байгууллага, түүний сургалтын материаллаг бааз, хүний нөөц болон суралцагсдын бүртгэл, мэдээллийг хамруулах;

- зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн сан /Тээврийн цагдаагийн алба/-д зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо бүртгэл, мэдээллийг хамруулах;
- жолоочийн эрүүл мэнд, зам тээврийн ослод өртсөн хүний бүртгэл, мэдээллийн сан /Эрүүл мэндийн яам/-д механикжсан тээврийн хэрэгслийн жолоочийн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэл, мэдээллийг хамруулах;
- жолоочийн даатгалын мэдээллийн сан /Албан журмын даатгагчдын холбоо/-д даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, хохирогчид олгосон нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой бусад бүртгэл, мэдээллийг хамруулах;
- авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын бүртгэл, мэдээллийн сан Татварын ерөнхий газр/-д тухайн төрлийн татварын бүртгэл, мэдээллийг хамруулах.
- хяналтын төхөөрөмжийн хяналт, зохицуулалтын бүртгэл, мэдээллийн сан /Зам, тээврийн хөгжлийн яам/-д хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төхөөрөмжийн засвар, үйлчилгээний байгууллагын бүртгэл, ашиглалт, засварын түүх, картын бүртгэл, мэдээллийг хамруулахаар заасан байна.

Хуулийн 10.3-т Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг Үндэсний зөвлөл батлахаар заасны дагуу “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лаавлагаа өгөх журам”-ыг Үндэсний зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар баталж, 01 дугаар тогтоол гаргасан.

Журмын 2.3-т зааснаар бүртгэл, мэдээллийн санг хөтлөх Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, Албан журмын даатгагчдын холбоо зэрэг байгууллага сар бүрийн 20-ны өдөр мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг ирүүлэх бөгөөд эдгээр мэдээллийг ашиглахаар нэгтгэн сарын эмхэтгэл мэдээлэл болгож Та бүхний албан хэрэгцээнд хүргүүлж байна.

## **“ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ”**

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭЛЭЛ

**Нэг. Автотээврийн хэрэгслийн мэдээлэл**
/Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн сан/

*1.1 Автотээврийн хэрэгслийн үзлэг тооллого, шинэчилсэн бүртгэлийн ажлын тухай*

- ❖ Монгол Улсын Засгийн газрын 2022.09.28-ны өдрийн 47 дугаар хуралдааны тэмдэглэлд Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, тэнцээгүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар, агаарын бохирдлын төлбөрөө төлөөгүй автотээврийн хэрэгслийг авто замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг ХЗДХС, ЗТХС, НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт даалгасан.

- ❖ ЗТХСайд, Сангийн сайдын хамтарсан Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай 2023.03.03-ны өдрийн А/57/48 тоот тушаалд Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нийцүүлэн автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхийг даалгасан.

- ❖ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.05.04-ний өдрийн А/140 дүгээр тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д нэмэлт өөрчлөлт орсон. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/48 дугаар тушаалаар ”Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдаагаар зохион байгуулах журам”-д нэмэлт өөрчлөлт орсон.

- ❖ ЗТХСайдын 2023.02.27-ны өдрийн Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө батлагдсан

Дээрх шийдвэрүүдийн хүрээнд АТҮТ ТӨҮГ-ын захирлын 2023.03.16-ны өдрийн А/67 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, 2023.03.13-нд батлагдсан Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл үзлэг, тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулсан байна. ЦЕГ, ТатЕГ болон Нийслэлийн захирагчын алба, 21 аймгийн засаг дарга нарт 2023.03.16-ны өдрийн 1/297 тоот албан бичгээр хамтран ажиллах тухай албан бииг болон зааврыг хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2023.04.24-ний өдрийн А/402 тоот захирамж ажлын хэсэг байгуулагдаж, 2023.05.11-ний өдөр тус ажлын хэсэг хуралдахад АТҮТ ТӨҮГ-аас шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааны талаарх танилцуулгыг өгсөн. Хурлаас шинэчилсэн бүртгэлд хамрагдах тээврийн хэрэгслийн судалгааг дүүрэг бүрээр гарган нийслэлийн засаг даргын тамгийн газар болон дүүргүүдэд хүргүүлсэн. Түүнчлэн 2023.05.15-25-ны өдрийн хооронд нийслэлийн дүүргүүдэд ажиллах баг хороо, нийгмийн ажилтан нарт шинэчилсэн бүртгэлтэй холбоотой мэдээлэл болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна. Мөн АТҮТ ТӨҮГ-аас 21 аймгийн Автотээврийн төвийн дарга, бүртгэлийн мэргэжилтэнүүдтэй нийт 7 удаагийн цахим хурал зохион байгуулж, нэгдсэн мэдээлэл болон тухай бүр авч хэрэгжүүлэх ажлын

талаар чиглэл өгч ажилласан. Шинэчилсэн бүртгэлд нийслэлд 9 дүүргийн 204 хорооны 827, орон нутагт 714   нийт 1541 албан хаагч ажилласан байна.

Улсын хэмжээнд нийт 1.264.542 тээврийн хэрэгсэл шинэчилсэн бүртгэлд хамрагдахаас 2023.06.30-ны   өдрийн байдлаар 1211366 буюу 96 хувь хамрагдсан.

| № | Салбарууд | Нийт тээврийн хэрэгслийн тоо | Шинэчилсэн бүртгэлийн задаргаа | | | | | | | үр дүн | | гүйцэтгэл хувиар % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Идэвхтэй тээврийн хэрэгслийн тоо | шинэчилсэн бүртгэлийн хүрээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан | цахим бүртгэлээс хассан | Түр журмын хүрээнд хасалтын хүсэлт хүлээн авсан | Техникийн шаардлага хангахгүй болон бусад | Нотариатын гэрээгээр бусдад шилжүүлсэн боловч өмчлөл шилжээгүй | Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тавьсан | Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан | Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй үлдсэн | |
| 1 | Архангай | 20183 | 12,819 | 1007 | 1762 | 261 | 3147 | 1180 | 7 | 20183 | 0 | 100% |
| 2 | Баян-Өлгий | 30218 | 15,619 | 2481 | 5659 | 1344 | 5021 | 81 | 13 | 30218 | 0 | 100% |
| 3 | Баянхонгор | 23901 | 15,208 | 768 | 3555 | 2314 | 367 | 1625 | 64 | 23901 | 0 | 100% |
| 4 | Булган | 18078 | 11,772 | 634 | 3802 | 203 | 245 | 1048 | 5 | 17709 | 369 | 98% |
| 5 | Говь-Алтай | 18265 | 11,410 | 527 | 3623 | 1298 | 815 | 237 | 6 | 17916 | 349 | 98% |
| 6 | Говьсүмбэр | 4609 | 2,830 | 183 | 586 | 319 | 669 | 20 | 2 | 4609 | 0 | 100% |
| 7 | Дархан-Уул | 32452 | 21,004 | 1316 | 6408 | 613 | 1138 | 49 | 32 | 30560 | 1892 | 94% |
| 8 | Дорноговь | 27019 | 17,697 | 1272 | 2560 | 1230 | 3900 | 341 | 19 | 27019 | 0 | 100% |
| 9 | Дорнод | 20666 | 12,634 | 1393 | 1188 | 683 | 2062 | 1026 | 28 | 19014 | 1652 | 92% |
| 10 | Дундговь | 15016 | 10,304 | 305 | 1905 | 237 | 1659 | 290 | 13 | 14713 | 303 | 98% |
| 11 | Завхан | 20154 | 12,733 | 598 | 2978 | 1072 | 501 | 1093 | 12 | 18987 | 1167 | 94% |
| 12 | Орхон | 35226 | 23,311 | 669 | 6109 | 1232 | 3626 | 204 | 75 | 35226 | 0 | 100% |
| 13 | Сэлэнгэ | 34478 | 22,691 | 1381 | 7332 | 585 | 1660 | 3 | 31 | 33683 | 795 | 98% |
| 14 | Сүхбаатар | 19597 | 10,773 | 652 | 4375 | 1014 | 2166 | 525 | 3 | 19508 | 89 | 99% |
| 15 | Төв | 26372 | 15,592 | 632 | 7274 | 754 | 963 | 606 | 9 | 25830 | 542 | 99% |
| 16 | Увс | 22807 | 13,498 | 1385 | 2828 | 1072 | 3903 | 14 | 19 | 22719 | 88 | 99% |
| 17 | Ховд | 27709 | 16,750 | 504 | 5767 | 396 | 1312 | 326 | 24 | 25079 | 2630 | 91% |
| 18 | Хэнтий | 21997 | 15,372 | 796 | 3144 | 622 | 1540 | 90 | 15 | 21579 | 418 | 98% |
| 19 | Хөвсгөл | 34504 | 20,153 | 1975 | 5444 | 871 | 1375 | 12 | 25 | 29855 | 4649 | 86% |
| 20 | Өвөрхангай | 33946 | 12,677 | 1209 | 8841 | 496 | 576 | 18 | 2 | 23819 | 10127 | 70% |
| 21 | Өмнөговь | 65510 | 45,851 | 1614 | 5955 | 1348 | 7918 | 221 | 73 | 62980 | 2530 | 96% |
| 22 | Нийслэл | 711835 | 426,305 | 49436 | 74068 | 19588 | 96612 | 16396 | 3854 | 686259 | 25576 | 95% |
| **Нийт дүн** | | 1264542 | 767003 | 70737 | 165163 | 37552 | 141175 | 25405 | 4331 | 1211366 | 53176 | 96% |
| **Нэгтгэл** | | **1264542** | **837740** | | **202715** | | **141175** | **25405** | **4331** | **1211366** | **53176** | **96%** |

<u>Автотээврийн хэрэгслийн үзлэг тооллого, шинэчилсэн бүртгэлийн ажлын үр дүнд:</u>

- ✓ ЗТХСайдын түр түтгэлзүүлэх тушаалын хүрээнд нийт **37552** иргэдийн хүсэлтийг хүлээн авч хасалт хийснээр 2024 оноос эхлэн татварын ногдол дахин нэмж үүсэхгүй байх асуудлыг шийдвэрлэсэн.
- ✓ Техникийн хяналтын үзлэгт улсын хэмжээнд нийт 514,633 буюу 46% нь  хамрагдсан. Энэ нь 2023 оны жилийн эцэст нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 75 орчим хувь үзлэг оншилгоонд хамрагдахаар байна.
- ✓ Нотариатын гэрээгээр худалдсан боловч худалдаж авсан иргэн нь шилжилт хөдөлгөөн хийлгээгүйн улмаас тухайн тээврийн хэрэгслийн торгууль, татвар өөрийнх нь нэр дээр үүсэж байгаа  **25,405** иргэн  байна. Эдгээр иргэдэд шилжилт хөдөлгөөн хийлгэх зайлшгүй шаардлага үүсэж байгаа талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн.
- ✓ Дахин ашиглах боломжгүй болсон тээврийн хэрэгслийг бүртгэлийн сангаас хассанаар улсын хэмжээний бодлого төлөвлөлтөд тоон мэдээ бодитойгоор гарна.

<u>Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:</u>

- Түр түдгэлзүүлэх тушаалын хүрээнд авсан иргэдийн хүсэлтэд дурдсан тээврийн хэрэгслийн улсын дугаарын жагсаалтыг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлэн бүртгэлийн программд дугаарыг хязгаарлах;

- ТатЕГ, ТЦА-т хасагдсан улсын бүртгэлийн дугаарын жагсаалтыг албан тоотын хамт хүргүүлж үүссэн торгууль, татварын ногдлыг иргэний бүртгэлийн дугаар дээр, ААНБ-ын хувьд регистр дээр болгох;
- Е-монголиа цахим сайтаар иргэдэд техникийн хяналтын үзлэгийн хугацааг сануулсан мессеж тогтмол явуулдаг болох;
- Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журамд нотариатын гэрээгээр худалдсан иргэдийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн талаар нэмэлт заалт оруулах санал боловсруулах;
- Гэрээ хэлэлцээрээр тээврийн хэрэгслээ бусдад худалсан бол тухай бүрт нь бүртгэлийн байгууллагад хандан шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийлгэж байх талаарх мэдээллийг хэвлэл мэдээллээр тогтмол явуулах;
- Түр журмаар хассан тээврийн хэрэгслийг сэргээх эрх зүйн орчин бүрдүүлэн программанд холбогдох хөгжүүлэлт хийх.

*1.2 Тээврийн хэрэгслийн бүртгэлин үйл ажиллагаа:*

Улсын хэмжээнд 2023.12.31-ний өдрийн  байдлаар нийслэлд 697,532 /58,5%/, орон нутагт 494,144  /41,5 %/ нийт 1,191,676 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.




*Шинээр бүртгэсэн тээврийн хэрэгсэл*

Тайлант хугацаанд нийт 116,458 тээврийн хэрэгслийг шинээр бүртгэсэн. 2022 оны мөн
үеийнхээс 19,000 тээврийн хэрэгсэл буюу 19.5%-иар өссөн дүнтэй байна.




*Шилжилт хөдөлгөөн*

2023 оны эхний хагас жилд нийт 636,428 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн өөрчлөлтийг бүртгэсэн. 2022 оны мөн үеийнхээс 114,824 тээврийн хэрэгсэл буюу 22 %-иар өссөн дүнтэй байна.




*Тээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олголт*

Нийт 26,955 тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгосон байна. 2022 оны мөн үеийнхээс 10,376 тээврийн хэрэгсэл буюу 62%-иар өссөн дүнтэй байна.




*Орон нутаг дах бүртгэлийг аймгуудаар харуулвал:*

Тайлант хугацаанд орон нутгийн 21 аймгийн 23 салбарт импортын бүртгэл 7,765 шилжилт хөдөлгөөн, өөрчлөлт бүртгүүлсэн 136,684 нийт 144,449 автотээврийн хэрэгслийн бүртгэл хийгдэж гэрчилгээ олгогдсон.



| Төрөл | Архангай | Баян-Өлгий | Баянхонгор | Булган | Говь-Алтай | Говьсүмбэр | Дархан-Уул | Дорноговь | Дорнод | Дундговь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Суудал | 11753 | 16165 | 13133 | 8744 | 9094 | 2706 | 20302 | 14297 | 13139 | 7656 |
| Ачаа | 7634 | 4552 | 4177 | 5416 | 3145 | 798 | 5299 | 3906 | 4900 | 3768 |
| Автобус | 314 | 918 | 675 | 175 | 601 | 80 | 379 | 753 | 474 | 333 |
| Тусгай | 108 | 202 | 204 | 83 | 90 | 61 | 214 | 228 | 161 | 122 |
| Цистерн | 12 | 54 | 47 | 28 | 22 | 41 | 96 | 105 | 83 | 30 |
| Зүтгүүр | 81 | 137 | 103 | 13 | 52 | 65 | 129 | 3212 | 276 | 33 |
| Механизм | 77 | 128 | 148 | 99 | 75 | 55 | 623 | 226 | 219 | 85 |
| Чиргүүл | 199 | 307 | 177 | 93 | 112 | 109 | 359 | 3422 | 419 | 58 |
| Мотоцикл | 423 | 2821 | 1274 | 762 | 1675 | 194 | 431 | 474 | 1281 | 1740 |
| **Нийт** | **20601** | **25284** | **19938** | **15413** | **14866** | **4109** | **27832** | **26623** | **20952** | **13825** |
| Баруун | 11667 | 11275 | 11859 | 8104 | 7847 | 2410 | 17715 | 11383 | 12498 | 7132 |
| Зүүн | 8235 | 10770 | 6481 | 6356 | 5158 | 1341 | 8701 | 11118 | 6535 | 4812 |
| **Нийт** | **19902** | **22045** | **18340** | **14460** | **13005** | **3751** | **26416** | **22501** | **19033** | **11944** |
| Бензин | 7216 | 17071 | 9644 | 6163 | 6709 | 1760 | 9774 | 8583 | 7149 | 6182 |
| Дизель | 8276 | 4524 | 5338 | 5864 | 4574 | 1066 | 6701 | 8271 | 6369 | 4144 |
| Цахилгаан | 3 | 0 | 7 | 1 | 0 | 0 | 16 | 2 | 4 | 4 |
| Газ | 92 | 132 | 108 | 259 | 48 | 91 | 1027 | 397 | 95 | 152 |
| Хосолсон | 4801 | 3239 | 4646 | 3014 | 3412 | 1075 | 9905 | 5865 | 6812 | 3227 |
| **Нийт** | **20388** | **24966** | **19743** | **15301** | **14743** | **3992** | **27423** | **23118** | **20429** | **13709** |
| 0-3 | 175 | 614 | 325 | 173 | 389 | 100 | 492 | 808 | 424 | 317 |
| 4-6 | 402 | 1411 | 764 | 442 | 865 | 173 | 502 | 923 | 771 | 954 |
| 7-9 | 796 | 1066 | 1056 | 913 | 964 | 272 | 1749 | 1704 | 1298 | 1072 |
| 10 ба түүнээс дээш | 19228 | 22193 | 17793 | 13885 | 12648 | 3564 | 25089 | 23188 | 18459 | 11482 |
| **Нийт** | **20601** | **25284** | **19938** | **15413** | **14866** | **4109** | **27832** | **26623** | **20952** | **13825** |
| 1500 см3 хүртэл | 7011 | 9493 | 7953 | 5609 | 6218 | 1455 | 8200 | 6247 | 8463 | 6189 |
| 1501-2500 см3 | 8845 | 8774 | 7114 | 6630 | 4680 | 1706 | 13544 | 8643 | 8154 | 4762 |
| 2501-3500 см3 | 3157 | 3395 | 2833 | 2123 | 2653 | 435 | 2894 | 3159 | 2174 | 1935 |
| 3501-4500 см3 | 649 | 1093 | 768 | 428 | 663 | 101 | 702 | 712 | 542 | 427 |
| 4501 см3 дээш | 719 | 2177 | 1069 | 505 | 524 | 293 | 1991 | 4390 | 1166 | 431 |
| Нийт | 20381 | 24932 | 19737 | 15295 | 14738 | 3990 | 27331 | 23151 | 20499 | 13744 |

| Завхан | Орхон | Сэлэнгэ | Сүхбаатар | Төв | Улаанбаатар | Увс | Ховд | Хэнтий | Хөвсгөл | Өвөрхангай | Өмнөговь | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10114 | 23719 | 17679 | 9663 | 11413 | 505350 | 12425 | 13674 | 12248 | 19441 | 16307 | 18413 | 787435 |
| 5836 | 4510 | 9017 | 4920 | 7709 | 83415 | 4911 | 4791 | 5735 | 8820 | 7211 | 5345 | 195815 |
| 429 | 582 | 350 | 283 | 290 | 12463 | 532 | 595 | 423 | 1051 | 559 | 1094 | 23353 |
| 123 | 252 | 193 | 64 | 118 | 6908 | 144 | 157 | 120 | 259 | 137 | 558 | 10506 |
| 46 | 87 | 56 | 29 | 62 | 2937 | 38 | 46 | 35 | 73 | 37 | 218 | 4182 |
| 40 | 123 | 264 | 798 | 45 | 26804 | 77 | 1642 | 59 | 192 | 304 | 14450 | 48899 |
| 85 | 383 | 605 | 45 | 339 | 11939 | 144 | 171 | 142 | 176 | 262 | 940 | 16966 |
| 151 | 304 | 539 | 914 | 158 | 39999 | 179 | 1646 | 248 | 381 | 645 | 22560 | 72979 |
| 944 | 488 | 1367 | 661 | 942 | 7717 | 2944 | 1045 | 779 | 1139 | 1699 | 741 | 31541 |
| **17768** | **30448** | **30070** | **17377** | **21076** | **697532** | **21394** | **23767** | **19789** | **31532** | **27161** | **64319** | **1191676** |
| 9104 | 20135 | 15764 | 9302 | 10999 | 438219 | 11124 | 11778 | 11578 | 17804 | 15613 | 16532 | 689842 |
| 7483 | 9141 | 11796 | 6456 | 8638 | 199678 | 7007 | 9126 | 7040 | 12034 | 8943 | 23547 | 380396 |
| **16587** | **29276** | **27560** | **15758** | **19637** | **637897** | **18131** | **20904** | **18618** | **29838** | **24556** | **40079** | **1070238** |
| 7434 | 12163 | 11769 | 4875 | 7778 | 231649 | 11344 | 8852 | 7844 | 13530 | 10923 | 11764 | 420176 |
| 6959 | 6239 | 9964 | 6421 | 8538 | 148499 | 5857 | 7817 | 6741 | 10378 | 8947 | 23390 | 304877 |
| 0 | 9 | 2 | 6 | 2 | 975 | 0 | 1 | 9 | 3 | 1 | 25 | 1070 |
| 73 | 968 | 697 | 68 | 229 | 8316 | 48 | 67 | 129 | 305 | 176 | 127 | 13604 |
| 3126 | 10720 | 7021 | 5066 | 4318 | 266587 | 3935 | 5338 | 4787 | 6905 | 6425 | 6404 | 376628 |
| **17592** | **30099** | **29453** | **16436** | **20865** | **656026** | **21184** | **22075** | **19510** | **31121** | **26472** | **41710** | **1116355** |
| 206 | 433 | 623 | 508 | 289 | 43610 | 795 | 682 | 309 | 576 | 507 | 14478 | 66833 |
| 521 | 675 | 657 | 551 | 601 | 26659 | 1566 | 946 | 613 | 714 | 1181 | 9640 | 51531 |
| 834 | 2134 | 1659 | 1138 | 1197 | 71712 | 1530 | 1516 | 1253 | 1050 | 1521 | 2611 | 99045 |
| 16207 | 27206 | 27131 | 15180 | 18989 | 555552 | 17503 | 20623 | 17614 | 29192 | 23952 | 37590 | 974268 |
| **17768** | **30448** | **30070** | **17377** | **21076** | **697533** | **21394** | **23767** | **19789** | **31532** | **27161** | **64319** | **1191677** |
| 6254 | 9536 | 9281 | 6429 | 7229 | 189087 | 9288 | 8895 | 7912 | 11592 | 10479 | 8289 | 351109 |
| 6614 | 13430 | 13385 | 5937 | 9324 | 276988 | 6629 | 7073 | 7261 | 11214 | 10382 | 9837 | 450926 |
| 2889 | 4056 | 3426 | 2364 | 2848 | 82459 | 3214 | 2641 | 2739 | 5194 | 3256 | 3801 | 143645 |
| 912 | 976 | 836 | 436 | 560 | 28442 | 878 | 838 | 753 | 1508 | 789 | 2323 | 45336 |
| 931 | 2090 | 2503 | 1276 | 871 | 77786 | 1171 | 2640 | 846 | 1606 | 1572 | 17350 | 123907 |
| 17600 | 30088 | 29431 | 16442 | 20832 | 654762 | 21180 | 22087 | 19511 | 31114 | 26478 | 41600 | 1114923 |

## Хоёр. Автозамын нөхцөл байдлын мэдээлэл

Монгол Улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин километр нутагтай, дэлхийд газар нутгийнхаа хэмжээгээр 19-д жагсдаг. Монгол Улсад авто замын дэд бүтэц нийт нутгийг хамран төдийлэн сайн хөгжөөгүй тул замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байна. Монгол Улсын авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутаг, тусгай зориулалт, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам гэж ангилагддаг бөгөөд нийтдээ 111 916.7 км авто замаас бүрддэг. Нийт авто замын сүлжээнээс 4 299.3 км авто зам нь олон улсын, 14 921.3 км нь улсын чанартай авто замд хамаарагдах бөгөөд үүний 7485.6 км нь хатуу хучилттай авто замаар ашиглагдаж байна. Тусгай зориулалтын буюу уул уурхайн тээвэрлэлтийн зориулалт бүхий 898.4 км авто зам ашиглагдаж байна.

Монгол Улс нь Азийн авто замын сүлжээ /АН-3, АН-4, АН-32/, Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC) /4a, 4b, 4c/, Их түмэн гол санаачилга (GTI) /1a, 1b/ зэрэг олон улсын авто замын сүлжээнд нэгдэн орсон бөгөөд ОХУ, БНХАУ, Монгол Улс хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт 3 чиглэлд авто замын коридорыг хөгжүүлэх зорилт тусгагдсан. Монгол Улс авто замын сүлжээгээ өргөтгөн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, тэргүүн ээлжинд олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх зорилт тавин, энэ хүрээнд Азийн авто замын сүлжээний АН-3, АН-4 чиглэлийн авто замын сүлжээнд хамаарах Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам буюу Ярант-Ховд-Өлгий-Улаан байшинт чиглэлийн авто замыг хөгжүүлэх, бүх аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтыг авч хэрэгжүүлсний үр дүнд 2021 онд 21 аймаг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дүгээр тушаалаар Зам, тээврийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг баталж “Нутгийн зам” дэд хөтөлбөр батлан суурин газрыг хатуу хучилттай замаар холбох ажлыг хэрэгжүүлж эхэлснээр нийт 104 сумыг хатуу хучилттай авто замаар холбох ажил хийгдээд байна.

Сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, хатуу хучилттай авто замын сүлжээний урт нэмэгдэж ая тухтай, аюулгүй зорчих нөхцөл бүрдэж байна. Гэвч баригдсан авто замын сүлжээний ашиглалтын хугацаа уртсаж, норм нормативын дагуу зайлшгүй хийгдэх арчлалт, засварын ажил шаардлагын хэмжээнд хийгдэж чадахгүй байгаагаас авто замд ихээхэн эвдрэл гарч аюулгүй зорчих нөхцлийг хангаж чадахгүйд хүрч байна. /Нийт авто замын хучилтын байдал. Хүснэгт 1/

Улсын чанартай авто замын хучилтын байдал. Хүснэгт 1.

| Улсын чанартай авто замын хучилтын төрөл | | Авто замын урт /км/ |
|---|---|---|
| а/ Хатуу хучилттай | | 7485.6 |
| Үүнээс: | Цемент бетон | 8.6 |
| | Асфальт бетон | 7 477,0 |
| б/ Хайрган хучилттай | | 905.7 |
| в/ Сайжруулсан хөрсөн | | 347.3 |
| г/ Ердийн хөрсөн зам | | 6 182.7 |
| **НИЙТ** | | 14 921.3 |

Улсын чанартай авто замд ашиглаж байгаа гүүрийн хэмжээ. Хүснэгт 2.

| Гүүрүүд | Нийт /ш/ | Нийт урт/метр |
|---|---|---|
| А: Улсын чанартай замд | | |

| | | | |
|---|---|---|---|
| Үүнээс: | Төмөр бетон гүүр | 317 | 14769.57 |
| | Ган гүүр | 1 | 284.0 |
| | Модон гүүр | 56 | 1057.7 |
| Нийт | | 374 | 16 111.27 |

**Улсын чанартай авто замын сүлжээ. Зураг 1.**




Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн хүчин зүйлийн нэг бол авто замын сүлжээнд аюулгүй зорчих ашиглалтын бэлэн байдлыг хангах асуудал юм. Бэлэн байдлыг хангахад авто замын насжилт, ашиглалтын байдлын үнэлгээ чухал нөлөөтэй байдаг. /Авто замын насжилтын байдал. Хүснэгт 3./

Авто замын насжилт. Хүснэгт 3.

| № | Хатуу хучилттай авто замын насжилт, жил | Урт, км | Эзлэх хувь, % |
|---|---|---|---|
| 1 | 6 жил хүртэл | 1264.1 | 16.9 |
| 2 | 6-13 жил | 4227.8 | 56.5 |
| 3 | 13-аас дээш жил | 1993.7 | 26.6 |
| Нийт | | 7485.6 | 100 |

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалгаалан авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагатай засвар арчлалтыг хийж гүйцэтгэх хөрөнгө оруулалт норм, нормативын хэмжээнд хийгдэж чадахгүй байна.

Тухайлбал олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын түвшинг бууруулахгүйгээр байнгын бэлэн байдлыг хангахад нормативын дагуу жилд урсгал засвар болон арчлалтад 113 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай боловч жил бүр улсын төсвийн хөрөнгөөс нийт шаардагдах хөрөнгийн дөнгөж 30-50 хувь шийдвэрлэж байна. Энэ нь жил ирэх тутам засвар, арчлалт бүрэн хийгдэхгүй байгаагаас замын ашиглалтын бэлэн байдлыг хангахад хүндрэлтэй болж байна. /Урсгал засвар, арчлалтын хөрөнгө оруулалт 2016-2023 он. Хүснэгт 4/

Хүснэгт 4.




Авто замын салбарт 2023 онд засвар арчлалтын ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр 7 байршилд 56.2 км авто замын их засварын ажил хийгдэж, ажлын гүйцэтгэл 92%-тай, АХБ-ны санхүүжилтээр 57.56 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажил хийгдэж, ажлын гүйцэтгэл 88.2%-тай явж байна. Ээлжит засварын ажлын хүрээнд Налайх-Тэрэлж, Ховд-Өлгий, Өндөрхаан-Чойбалсан, Хархорин-Цэцэрлэг, Улаанбаатар-Өндөрхаан, Улаанбаатар-Арвайхээр, Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн нийт 72.3 км авто замын ажил хийгдэж, нийт ажлын гүйцэтгэл 74%-тай байна. Мөн Улсын чанартай 14 921.3 км авто замын засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 82%-тай хэрэгжиж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зам, тээврийн хөгжлийн яамтай 2023 онд гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт 755.1 км авто замын барилга угсралтын ажил, 230 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажил, гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр нийт 261.5 км авто замын барилга угсралтын ажил, мөн 201.08 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажил, Төр хувийн хэвшлийн түншлэлээр буюу концессын гэрээгээр нийт 1237.5 км авто замын барилгын ажил хийгдэж байна.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд /UNESCAP, CAREC зэрэг/ нь бүс нутгаараа хамтран эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх зорилгод бүс нутгийг дамнасан авто замын коридоруудыг хөгжүүлэх зорилт тавьсан бөгөөд Баруун босоо, Хэвтээ тэнхлэгийн коридорын дагуух хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратеги, бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

## Гурав. Жолооч нар болон сургалтын байгууллагын мэдээлэл

*3.1. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын сонсогчдоос шалгалт авах чиглэлээр:*

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/46, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”-ын дагуу давхардсан тоогоор 15942 шалгуулагчаас замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалт авснаас 11312 буюу 70,9 хувь, 6881 шалгуулагчаас замын хөдөлгөөний жолоодлогын шалгалт авснаас 5946 буюу 86,4 хувь, 2162

шалгуулагчаас талбайн жолоодлогын шалгалт авснаас 1992 буюу 92,1 хувь нь тэнцсэн байна.

Жолоочийн бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, үнэмлэх олгох, хэвлэх чиглэлээр: Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”-ын дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох шалгалтад тэнцсэн шинээр жолооч болсон 5946, ангилал нэмсэн 1992, жолоодох эрхийн үнэмлэх нөхөн олгосон 12863, олон улсын жолоодох эрхийн үнэмлэх олгосон 386, гадаад улсын жолоодох эрхийн үнэмлэх солилт, сунгалтаар 178 иргэний материалыг тус тус хүлээн авч, жолоочийн бүртгэлийн нэгдсэн сан /DLS/-д бүртгэж, үндэсний жолоодох эрхийн үнэмлэх 15955, олон улсын жолоодох эрхийн үнэмлэх 178 ширхэгийг тус тус хэвлэж олгосон.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээх үйл ажиллагааны чиглэлээр: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/142 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээх журам”-ын дагуу Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан 2102, Эрүүгийн хуулийн холбогдох заалтын дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан 46 жолоочийн мэдээллийг жолоочийн бүртгэлийн сан /DLS/-д хасаж бүртгэсэн.

Мөн журмын 4 дэх хэсэгт заасны дагуу нийслэл, орон нутгийн тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх сургалтын байгууллагуудын сургалтад хамрагдсан эрх сэргээх 3105, зөрчлийн бүртгэлийн оноо нэмэх 417 иргэний материалыг хянаж, мэдээллийн санд бүртгэсэн байна.

| д/д | Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт | | | | | | | | | Шинээр жолоодох эрх | Ангилал нэмсэн | Жолоодох эрхийн үнэмлэх нөхөн олгосон | Олон улсын жолоодох | Гадаад улсын жолоодох | Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан | | Тээврийн хэрэгсэл жолоодох эрх, зөрчлийн оноо нэмсэн | | Нийт хэвлэгдсэн үнэмлэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Замын хөдөлгөөний хууль, дүрэм | | | Замын хөдөлгөөний жолоодлого | | | Тусгай талбайн жолоодлого | | | | | | | | Зөрчлийн тухай хуулиар | Эрүүгийн хуулиар | Жолоодох эрх сэргээсэн | Оноо нэмсэн | |
| 2 | Шалгагдсан | Тэнцсэн | Хувь | Шалгагдсан | Тэнцсэн | Хувь | Шалгагдсан | Тэнцсэн | Хувь | | | | | | | | | | |
| 3 | 15942 | 11312 | 70,9% | 6881 | 5946 | 86,4% | 2162 | 1992 | 92,1% | 5946 | 1992 | 12863 | 386 | 178 | 2102 | 46 | 3105 | 417 | 15955 |

## *3.2 Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагууд*

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.5, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйл, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 161/229 дугаар “Сургалтын хөтөлбөр, журам, үнэмлэхийн загвар батлах тухай /Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр/” тушаалыг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын байдлаар жолооны мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн хамт нийт

285 тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын төвд хяналт үнэлгээ хийсэн.

2023 оны 08 дугаар сарын байдлаар Бүртгэлийн гэрчилгээтэй холбоотой нийт 285 тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын хүсэлт ирснээс:

- Бүртгэлийн гэрчилгээ сунгуулсан 48 байгууллага,
- Шинээр 174 байгууллага.
- Шаардлага хангаагүй буюу түр түдгэлзүүлсэн 63 байгууллагад арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

2015 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр”, “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам” -ын хэрэгжилтийг тус тус хангуулах, тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагуудын багшлах боловсон хүчин, сургалтын анги танхим, дадлагын тээврийн хэрэгсэл, дадлагын тусгай талбай /автодром/ зэргийн хууль, журам, стандартын шаардлагыг хангаж буй эсэх, авто сургуулийн суралцагчдын дадлагын хичээлийн хөтөлбөр хангалт болон урьдчилан шалгалтад тавих хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор 1 сарын хугацаат /2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл/ ажлыг ЦЕГ-ын БХТ-тэй хамтран зохион байгуулсан. Нийслэлийн төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын төвүүд хамрагдсан.

Тус ажлын хүрээнд:

- Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгагдсан тусгай талбай /автодром/ -ын ачааллыг тооцох, дадлагын хичээлийн хөтөлбөрийг хангуулах
- Жолооч бэлтгэх сургалтын байгууллагын суралцагчдаас сургалтын байгууллагын удирдлагаас авч буй урьдчилсан шалгалтын явцад хяналт тавих
- Тээврийн хэрэгслийн жолоодох эрх олгох онолын болон дадлагын шалгалтад удаа дараа буруу хариулж шалгагдсан сургалтын байгууллагыг сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих.
- Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын жолоодлогын дадлагын багш нараас замын хөдөлгөөний хууль, дүрмийн онолын шалгалт авах, хангалтгүй дүгнэгдсэн багш нарт давтан сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс санаачлан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ” нөлөөллийн арга хэмжээг Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл, хяналтын төв, Монголын улаан загалмайн нийгэмлэг, Монголын авто сургалтын байгууллагуудын нэгдсэн холбоотой хамтран энэ оны 4 дүгээр сарын 07 өдөр Улаанбаатар хотод эхлүүлж, 6 дугаар сарын 16-нийг хүртэл 2 сарын хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагуудын захирал, багш, суралцагч нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Дэвжээ” тэмцээнийг улс даяар, бүсчилсэн хэлбэрээр 05 дугаар сарын 17-оос 06 дугаар сарын 16-ний өөр хүртэл зохион байгуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс санаачлан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын төвүүдийн дунд “САЙНЫГ ТҮГЭЭЕ” чалленж эхлүүлэн байгууллагын фэйс бүүк пэйж хуудсанд нийтлэх хэлбэрээр нийтэд түгээж байна. Одоогоор 4 тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын төвийн үйл ажиллагааг онцолсон байна.

*3.3 Мэргэшсэн жолооч бэлтгэх үйл ажиллагаа:*

Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалт нь:

- ✓ хууль тогтоомж-тээвэрлэлтийн арга зүй;
- ✓ техникийн мэдлэг-засвар үйлчилгээ;
- ✓ жолоодлого-үйлдвэрлэлийн дадлага гэсэн үндсэн 3 хэсгээс бүрддэг.

Техникийн мэдлэг - засвар үйлчилгээ хичээлийн сургалт нь танхимд болон дадлага ажлын гэсэн 2 хэлбэрээр явуулж байна.

*Жолоодлого* - үйлдвэрлэлийн дадлагын хичээлийн сургалт нь тусгайлан бэлтгэсэн талбай /автодром/-н жолоодлогын дадлага болон үйлдвэрлэлийн дадлага гэсэн 2 хэлбэрээр явагдана.

*Техникийн мэдлэг* – засвар үйлчилгээ хичээлийн дадлагыг үйлдвэрлэлийн дадлагатай хамт эрх бүхий сургалтын байгууллагаас сургалт-үйлдвэрлэл, дадлагын бааз болгон ажиллуулахаар хамтран ажиллах гэрээ байгуулсан тухайн чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага дээр хийнэ.

Мэргэшсэн жолоочийн шалгалтанд хамрагдахыг хүссэн этгээд дараах материал бүрдүүлдэг байна. Үүнд:

1. Жолооны үнэмлэх /эх хувь/;
2. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хуудас /тухайн жилийн/
3. 4х6 хэмжээтэй, өнгөт гэрэл зураг 1 хувь
4. Шалгалтын төлбөр тушаасан баримт /9900 төгрөг/
5. Үнэмлэхний үнэ тушаасан баримт /12500 төгрөг/
6. Улсын тэмдэгтийн хураамж тушаасан баримт /1000 төгрөг/
7. Сургалтын хөтөлбөр хангасан байх /2008 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс хойш тухайн ангилал авсан этгээд/

Жолооч нар өөрт ойрхон, мэргэшсэн жолоочийн сургалт явуулах эрх бүхий авто сургуулиудад хандаж, сургалтад 168 цаг буюу 21 өдөр хамрагдана. Харин шалгалтыг “Автотээврийн Үндэсний төв”-ийн Мэргэшсэн жолоочийн тасагт авдаг.

2008 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс өмнө тухайн ангиллын /В,С,Д, Е/ жолоодох эрхийн үнэмлэх авсан этгээд шууд шалгалтанд орох эрхтэй ба мөн өдрөөс хойш тухайн ангиллын /В,С,Д, Е/ жолоодох эрхийн үнэмлэх авсан этгээд мэргэшсэн жолооч бэлтгэх эрх бүхий сургалтын байгууллагад “Мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр”-ийн дагуу сургалтад хамрагдах ба сургалтад бүрэн хамрагдсан жолооч нар шалгалтанд орох эрхтэй болно.

Мэргэшсэн жолоочийн үнэмлэхний хугацаа дууссан тохиолдолд тухайн ангиллаар шалгалт өгч тэнцсэн тохиолдолд сунгаж байна.

2023 оны 8 дугаар сард 1250 жолоочоос давхардсан тоогоор 1955 удаа ангилал бүрээр шалгалт авч 1066 тэнцсэн.

Шалтгалт ангилал тус бүрээр:

| № | Ангилал | Шинээр | | Сунгалт | |
|---|---|---|---|---|---|
| | | Орсон | Тэнцсэн | Орсон | Тэнцсэн |
| 1 | B | 86 | 35 | 21 | 7 |
| 2 | C | 37 | 19 | 37 | 19 |
| 3 | D | 364 | 182 | 364 | 182 |
| 4 | E | 763 | 381 | 763 | 381 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | УХАТ | 563 | 359 | 563 | 359 |
| 6 | УХЗТ | 43 | 25 | 43 | 25 |
| 7 | ЖУУ | 42 | 34 | 42 | 34 |
| 8 | АА | 57 | 31 | 57 | 31 |

## Дөрөв. Зам, тээврийн осол, хэргийн нөхцөл байдал

Энэ оны эхний 8 сард цагдаагийн байгууллагад зам тээврийн ослын шинжтэй 65941 дуудлага мэдээлэл ирснээс 15094 зам тээврийн осол, хэрэг бүртгэгдэж, 347 хүний амь нас хохирч, 2026 хүн хүнд, хөнгөн хэлбэрээр гэмтсэн байна. Тайлангийн хугацаанд хүүхэд өртсөн зам тээврийн осол хэрэг 589 бүртгэгдэж, 37 хүүхдийн амь нас хохирсон харамсалтай тоо мэдээлэлтэй байна.

Зам, тээврийн осол, хэргийн тоо мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дуудлага, мэдээлэл 10,8 хувь, бүртгэгдсэн зам тээврийн осол 0,6 хувь, зам тээврийн осол, хэргийн улмаас гэмтсэн хүний тоо 9,3 хувь, хүүхэд өртсөн зам тээврийн осол, хэрэг 21,9 хувь тус тус өссөн бол зам тээврийн осол, хэргийн улмаас нас барсан хүний тоо 5,7 хувь, зам тээврийн осол, хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо 27,5 хувь тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн 1,862,819 зөрчлийг илрүүлж, зөрчил үйлдсэн 1,718,829 жолоочийг 52,670,391,600 төгрөгийн торгууль оногдуулсан байна. Дээрх хугацаанд цагдаагийн нийтлэг үүрэг болон бусад хууль тогтоомж зөрчсөн зөрчил 505, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 30164, цаашид хөдөлгөөнд үргэлжлүүлэн оролцох боломжгүй зөрчил 35446 тус тус илрүүлж, 23560 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 5451 хүнийг баривчлах арга хэмжээ тооцсон байна.

| № | **Үзүүлэлт** | Нийслэл | | Орон нутаг | | **Улс** | | *нийслэл өсөлт, бууралт* | *орон нутаг өсөлт,* | ***улс өсөлт бууралт*** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022 оны эхний 8 сар | 2023 оны эхний 8 сар | 2022 оны эхний 8 сар | 2023 оны эхний 8 сар | 2022 оны эхний 8 сар | 2023 оны эхний 8 сар | | | |
| 1 | Зам тээврийн ослын шинжтэй дуудлага | 55990 | 61272 | 3514 | 4669 | 59504 | 65941 | *9.4* | *32.9* | *10.8* |
| 2 | Бүртгэгдсэн зам тээврийн осол | 12629 | 12569 | 2377 | 2525 | 15006 | 15094 | *-0.5* | *6.2* | *0.6* |
| 3 | Гэмт хэрэг | 409 | 396 | 438 | 459 | 847 | 855 | *-3.2* | *4.8* | *0.9* |
| | Үүнээс: согтуугаар үйлдэгдсэн | 49 | 43 | 124 | 113 | 173 | 156 | *-12.2* | *-8.9* | *-9.8* |
| 4 | Гэмт хэргийн улмаас нас барсан /статистик/ | 40 | 48 | 160 | 154 | 200 | 202 | *20.0* | *-3.8* | *1.0* |
| 5 | Бодит нас баралт | 59 | 67 | 309 | 280 | 368 | 347 | *13.6* | *-9.4* | *-5.7* |
| 6 | Хэргийн улмаас гэмтсэн хүн | 373 | 355 | 345 | 331 | 718 | 686 | *-4.8* | *-4.1* | *-4.5* |
| 7 | Гэмтсэн хүн /осол/ | 1087 | 1274 | 767 | 752 | 1854 | 2026 | *17.2* | *-2.0* | *9.3* |
| 8 | Хүүхэд өртсөн осол | 274 | 363 | 209 | 226 | 483 | 589 | *32.5* | *8.1* | *21.9* |
| | үүнээс нас барсан хүүхэд бодит | 6 | 2 | 45 | 35 | 51 | 37 | *-66.7* | *-22.2* | *-27.5* |
| 9 | Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол | 18,559,4 | 22,390,5 | 4,094,9 | 6,723,6 | 22.654.3 | 29.114.2 | *20.6* | *64.2* | *28.5* |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | үүнээс: нөхөн төлүүлсэн хохирол | 17,612,4 | 20,654,6 | 3,186,6 | 5,560,0 | 20:799:0 | 26.214.7 | *17.3* | *74.5* | *26.0* |
| № | Зүйл /Ангилал/ | Даатгалын гэрээний тоо | Даатгалын хураамжийн дүн |
|---|---|---|---|
| 2 | A | 445 | 10,082,742 |
| 3 | B | 53,729 | 2,923,890,883 |
| 4 | C | 5,001 | 637,048,337 |
| 5 | D | 890 | 94,830,454 |
| 6 | M | 514 | 16,418,250 |
| 7 | Бусад | 4 | 442,260 |
| | Нийт | 60,583 | 3,682,712,926 |

*/* Мэргэшсэн жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүн ороогүй болно./*

## Долоо. Татварын байгууллагын мэдээлэл

Татварын ерөнхий газраас ЗХАБҮЗ-д авто тээврийн хэрэгслийн бүртгэл болон төлөлтийн мэдээлэл / 2023 /

| Аймаг нэр | TTToo | Т/Х-ийн тоо | АТБӨЯХАТ ногдол | АТБӨЯХАТ төлөлт | АБТ ногдол | АБТ төлөлт | АЗАТ ногдол | АЗАТ төлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Архангай | 18,397 | 20,849 | 760,651 | 433,090 | 56,144 | 28,810 | 133,847 | 85,015 |
| Багануур | 7,189 | 9,092 | 447,276 | 283,289 | 22,382 | 12,695 | 246,736 | 144,623 |
| Багахангай | 999 | 1,132 | 52,243 | 32,241 | 2,789 | 1,476 | 30,829 | 17,754 |
| Баянгол | 71,063 | 116,025 | 7,657,864 | 5,221,099 | 311,065 | 187,185 | 3,345,266 | 2,071,397 |
| Баянзүрх | 111,364 | 168,773 | 10,082,533 | 6,639,092 | 420,622 | 241,197 | 4,670,914 | 2,786,200 |
| Баян-Өлгий | 24,930 | 28,316 | 1,131,213 | 458,600 | 78,524 | 29,204 | 38,456 | 33,627 |
| Баянхонгор | 19,725 | 23,586 | 840,458 | 453,920 | 65,730 | 32,658 | 449,795 | 233,931 |
| Булган | 16,210 | 18,091 | 545,366 | 350,970 | 48,059 | 27,653 | 169,904 | 111,329 |
| Говь-Алтай | 15,821 | 18,180 | 563,634 | 331,858 | 48,260 | 24,789 | 29,549 | 24,848 |
| Говьсүмбэр | 3,983 | 4,684 | 175,531 | 97,426 | 17,620 | 8,355 | 32,870 | 19,919 |
| Дархан-Уул | 26,035 | 32,848 | 1,511,851 | 836,247 | 122,065 | 58,961 | 508,074 | 278,610 |
| Дорноговь | 19,617 | 27,293 | 1,437,031 | 875,589 | 83,671 | 47,531 | 72,330 | 64,053 |
| Дорнод | 16,816 | 21,042 | 688,976 | 407,647 | 54,280 | 28,727 | 39,026 | 32,415 |
| Дундговь | 12,959 | 14,994 | 453,817 | 260,339 | 36,256 | 19,794 | 87,737 | 56,451 |
| Завхан | 18,232 | 20,656 | 667,888 | 377,607 | 62,414 | 31,676 | 34,896 | 31,026 |
| Налайх | 8,835 | 10,471 | 523,447 | 311,489 | 26,093 | 13,726 | 285,189 | 155,995 |
| Орхон | 26,680 | 34,565 | 1,601,393 | 1,040,310 | 128,854 | 75,910 | 86,379 | 78,286 |
| Өвөрхангай | 27,550 | 33,372 | 1,183,730 | 665,508 | 89,243 | 40,671 | 467,232 | 246,732 |
| Өмнөговь | 25,792 | 66,572 | 10,996,942 | 9,652,743 | 231,989 | 162,754 | 565,552 | 396,160 |
| Сонгинохайрхан | 81,132 | 113,424 | 6,090,558 | 3,583,499 | 293,883 | 154,599 | 3,112,411 | 1,700,830 |
| Сүхбаатар | 16,744 | 20,781 | 834,774 | 561,715 | 80,744 | 44,411 | 73,403 | 59,390 |
| Сүхбаатар дүүрэг | 46,563 | 97,745 | 7,355,833 | 4,754,334 | 292,074 | 170,622 | 2,977,435 | 1,764,503 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сэлэнгэ | 28,141 | 33,787 | 1,215,970 | 668,679 | 148,000 | 73,369 | 379,062 | 213,142 |
| Төв | 22,961 | 26,470 | 796,475 | 470,799 | 116,296 | 63,177 | 246,104 | 152,470 |
| Увс | 18,592 | 21,625 | 953,097 | 484,421 | 82,757 | 38,757 | 31,798 | 25,977 |
| Хан-Уул | 61,291 | 96,094 | 7,156,607 | 5,300,212 | 274,445 | 179,029 | 2,849,809 | 1,874,185 |
| Ховд | 20,037 | 26,835 | 1,206,975 | 723,353 | 103,156 | 54,232 | 323,218 | 184,517 |
| Хөвсгөл | 29,804 | 35,684 | 1,191,289 | 670,837 | 154,391 | 79,148 | 365,928 | 209,081 |
| Хэнтий | 18,296 | 21,252 | 900,595 | 495,031 | 91,944 | 45,167 | 219,861 | 126,770 |
| Чингэлтэй | 43,512 | 75,851 | 4,927,566 | 3,186,993 | 194,977 | 109,292 | 2,112,167 | 1,216,084 |
| **Нийт дүн** | **859,270** | **1,240,089** | **73,951,582** | **49,628,936** | **3,738,727** | **2,085,575** | **23,985,779** | **14,395,319** |

## Найм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах зорилгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс үйл ажиллагааны чиглэл бүхий зөвлөмж, үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтоолоор батлан холбогдох байгууллага, засаг захиргааны нэгжийг удирдлагаар ханган ажиллаж байна.

2022 оны замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаанаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хэлэлцэж, “Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан бөгөөд хоёр дахь хуралдаанаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал”, “Жолооч бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох” асуудлыг хэлэлцэн холбогдох тогтоол, зөвлөмжийг батлаад байна. Баталсан тогтоол зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төсөлд холбогдох заалтуудыг тусгаж ажилласан.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг цөөрүүлэх, Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн паркийг шинэчлэх, зам тээврийн ослын улмаас хохирсон хүмүүст тусламж үзүүлэх тогтолцоог бүх суурин газарт бий болгох, жолоочийн шалгалт авахад хүний хүчин зүйлийг багасгах, зам, тээврийн төлөвлөлтийг хот төлөвлөлттэй уялдуулах, зам тээврийн ослыг шинжлэн шалгах үйл ажиллагаа хангалтгүй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөөлийн 2023.05.25-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2023.09.15-ны байдлаарх хэрэгжилтийн явцыг гаргаж үзэхэд 66,9 хувийн биелэлттэй явж байгаа бөгөөд цаашид хэрэгжилтийг бүрэн хангах хийх ажлын чиглэлийг холбогдох байгууллагуудад өгч ажиллаж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны
үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт /2023.09.15-ны байдлаар/

| № | Үйл ажиллагаа | Хариуцах байгууллага | Холбогдох байгууллага | Үйл ажиллагааны биелэлт | Цаашдын ажил |
|---|---|---|---|---|---|
| Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Алсын хараа-2050 Монгол Улсын урт, хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Зам, тээврийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөө, Зам тээврийн хөгжлийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг эрх зүйн болон хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлнэ. | | | | | |
| **1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, холбогдох байгууллагуудын уялдааг хангах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, бодлогын удирдамж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах** | | | | | |
| 1.1. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын "Цагаан ном"-ын эх бэлтгэх, хэвлүүлэх | ЗХАБҮЗ АА | ЭМЯ, ХНХЯ ХНХСҮСИ, ЗТХЯ АЗБЗГ, ЗТХТ, АТҮТ, ЦЕГ БХТ, ТЦА, АЖДХ | Холбогдох байгууллагуудаас мэдээллийг авч Цагаан номын эхийг бэлтгэж, хэвлүүлэх зардлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. 30% | 1. Мэдээллүүдийг цуглуулах /ЭМЯ, ТЦА, АТҮТ, АЗБЗГ, АЖДХ, .../<br>2. Санхүүжилт /АТҮТ, АЖДХ, МАТНХ/ |
| 1.2. | Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх | ЗХАБҮЗ АА, АТБЗГ | ЗТХЯ АЗБЗГ, ТЦА, ЗТХТ, АТҮТ, | ЗТХЯ-ны захиалгаар "Зам, тээврийн хүрээлэн" НҮТББ-аас 2016 онд "Хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бий болгох, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх судалгаа"-ны ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмжийн дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Аудитын тухай хуулиудад нэмэлт оруулах, үүний дагуу ЗТХ-ийн сайд, Үндэсний аудитын газрын даргын хамтарсан тушаалаар батлах "Хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх журам"ын төсөл, "Хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх аргачлал, Аудитын багийн мэдээллийн хуудас, | ЗТХ-ийн сайд, Үндэсний аудитын газрын даргын хамтарсан тушаалаар батлах "Хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх журам"ын төсөл, "Хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх аргачлал, Аудитын багийн мэдээллийн хуудас, Аудитын тайлангийн үлгэрчилсэн загварын төслүүдийг батлах эрх зүйн орчинг бүрдүүлж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Аудитын тухай хуулиудад нэмэлт оруулах /ЗТХЯ-ны АЗБЗГ, АТБЗГ, ТЦА/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Аудитын тайлангийн үлгэрчилсэн загварын төслүүдийг боловсруулсан. 50% | |
| 1.3. | ЗХАБ-ын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар аудит хийх | ЗХАБҮЗ АА | ЦЕГ БХТ, ТЦА, | Энэ оны эхний 8 сарын байдлаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгээгүй. 0% | Замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн чиглэлийн эрдэмтэн, судлаачдаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгээгэх<br>ТЦА, ЦЕГ-ын Бүртгэл, хяналтын төвтэй хамтран дэмжлэг үзүүлж зохион байгуулах<br>АЖДХ-ноос 30 сая төгрөгийн санхүүжилтийг 2024 он төсөвт тусгуулан шийдвэрлэх<br>"Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл (УБХТАЗТТ)"-ийн хүрээнд зарим ажлыг хийх боломжийг судалж хэрэгжүүлэх |
| 1.4. | Аюултай ачаа тээвэрлэлт /ADR/-ийн тухай хэлэлцээрт нэгдэх чиглэлээр ажиллах | ЗХАБҮЗ АА | ЗТХЯ АТБЗГ | Аюултай ачаа тээвэрлэлт /ADR/-ийн тухай хэлэлцээрийн орчуулгыг МАТНХ-ноос хийж байна. 30% | Аюултай ачаа тээвэрлэлт /ADR/-ийн тухай хэлэлцээрийн орчуулгыг дуусгах, |
| 1.5. | Цахилгаан скүүтер. Техникийн ерөнхий шаардлага. MNS.... :2023 Монгол Улсын стандартыг боловсруулж, батлуулах | ЗХАБҮЗ АА, ТЦА | ЗТХЯ АТБЗГ | Цахилгаан скүүтерийн стандартын төслийг боловсруулж, СХЗҮТ-д 2023.03.17-ны 04/1213 тоотоор хүргүүлсэн. ЗТХЯ-ны АТБЗГ-аас уг стандартын төслийг хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзсэний дагуу Стандартын Техникийн хорооноос буцааж татаж авсан. 50% | Шаардлагатай бол дахин хэлэлцүүлэх |
| 1.6. | "Жолоочийн эрүүл мэндэд тавих | ЭМЯ, ХЗДХЯ, | | ЭМЯ: Ажлын хэсэг байгуулж байгаа. Журам, бичиг | Хамтарч журмуудын төслийг боловсруулж дуусгах, батлуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шаардлага”, “Эрүүл мэндийн хуудас”, “Үзлэгийн хуудасны загвар”, “Үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн жагсаалт”, “Тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эмийн жагсаалт”, “Эмийн сангийн иж бүрдэл цуглуулгын жагсаалт” зэрэг журмын төслүүдийг эцэслэн батлуулах | ХНХЯ, ЦЕГ | | баримтын төслийг боловсруулж байна. 30% | |
| 1.7. | “Монгол Улсад тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгооны чадавхийг дээшлүүлэх, оношилгооны төвийг хөгжүүлснээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах төсөл (2023-2027)”-ийг хэрэгжүүлэх | ЗХАБҮЗ АА, АТҮТ | ЗТХЯ АТБЗГ | “Монгол улсад тээврийн хэрэгслийн үзлэг, оншилогооны чадавхыг дээшлүүлэх, оншилогооны төвийг хөгжүүлснээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах төсөл”-ийг 2023 онд эхлүүлэх Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайд, БНСУ-ын Койка байгууллагын хамтарсан гэрээг 06 дугаар сарын 28-29-ны өдрүүдэд байгуулахаар гэрээний төслийг эцэслэн боловсруулж, харилцан тохиролцсон. 2023.09.25-нд төслийг хэрэгжүүлэх Санамж бичгийг байгуулна. Үүний дараа төсөл хэрэгжиж эхэлнэ. 70% | “Монгол Улсад тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгооны чадавхийг дээшлүүлэх, оношилгооны төвийг хөгжүүлснээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах төсөл (2023-2027)”-ийг хэрэгжүүлж эхлэх |
| 1.8. | “Зам тээврийн ослын мэдээллийн зураглал, үнэлгээ, дүгнэлтийн програмыг | ЗХАБҮЗ АА, ХЗДХЯ, ЭМЯ, | | Дэлхийн банкны Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Улаанбаатар хотын тогтвортой авто зам, | Төслийн хүрээнд ЗХАБ-ын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд аудит хийлгэх асуудлыг тавьж шийдвэрлүүлэх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Улаанбаатар хотод нэвтрүүлэх” төслийг эхлүүлэх | | | тээвэр төсөл (УБХТАЗТТ)”-ийг хэрэгжүүлж байна. Тус төслийн Бүрэлдэхүүн хэсэг 3 (Зам, тээврийн төлөвлөлт, менежментийн үр дүнтэй институт)-ын Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.1 (Стратегийн судалгаа)-ийн хүрээнд Зам, тээврийн ослын бүртгэл, мэдээллийн платформ боловсруулах, суурилуулах Зөвлөх үйлчилгээний ажил төлөвлөгдсөн. УБХТАЗТТ-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс ажлын даалварын төслийг боловсруулан ЗТХЯ, ТЦА, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар зэрэг байгууллагуудаас ажлын даалгавар дээр санал авсан. 9 дүгээр сард ажлын даалгаврыг батлуулан тендерийн сонгон шалгаруулалтыг эхлүүлээр төлөвлөж байна. 70% | |
| 1.9. | “Зам тээврийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх” төслийг хэрэгжүүлэх | АТБЗГ, АЖДХ, ЗХАБҮЗ АА | | АХБ-ны "Тээврийн мэдээллийн системийг хөгжүүлэх" техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэгч баг болох TransConsult, PowerEd компанийн төлөөлөлтэй 7 хоног бүрийн Пүрэв гарагт онлайнаар болон биечлэн уулзаж хийж буй ажлын гүйцэтгэлийн явцтай танилцаж, зөвлөлдөж байна. Төслийн төлөвлөгөөнд орсон “Тээврийн ухаалаг систем”-ийг сайн нэвтрүүлсэн бодит үр дүнтэй танилцах аялалыг 2023.06.10-17-ны өдрүүдэд Сингапур, Малайз улсад зохион байгуулж, яамны 10 | төслийн хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан- цахим портал үүсгэх ажлыг хийх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | албан хаагч хамрагдсан. Танилцах аялалын хүрээнд АХБ-ны төлөөлөл, төсөл хэрэгжүүлэгч 2 байгууллагын төлөөлөгч нартай хамтран Сингапур улсын 4 байгууллага, Малайз улсын 2 байгууллага дээр очиж Тээврийн ухаалаг системийг хэрхэн нутагшуулж буй талаар бодит мэдээлэлтэй танилцсан.<br>2023.09.08-нд төслийн багийнхантай цахимаар, 2023.09.13-нд ЗТХЯ дээр уулзаж, төслийн хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг цуглуулах, нэгтгэх, нэгдсэн цахим портал үүсгэх, мэдээллийг боловсруулж олон нийт болон албан хэрэгцээнд ашигладаг болох боломжийг бүрдүүлэх талаар ярьж тохирсон. 70% | |
| 1.10 . | Уул уурхайн болон нийтийн хэрэгцээнээс бусад авто замын хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж гаргах | ЗХАБҮЗ АА, УУХҮЯ, ХЗДХЯ, ЦЕГ | | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны нэгдүгээр хурал энэ оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдах үед Тээврийн цагдаагийн албанаас “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал” сэдвээр танилцуулга, мэдээлэл хийсэн. 70% | Дараагийн хэлэлцүүлгийг 9-р сард зохион байгуулах |
| 1.11 . | ЗХАБҮЗ-ийн хурлыг зохион байгуулах | ЗХАБҮЗ АА | | 2023 оны 05 дугаар сарын 25-нд УИХ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, ЗХАБҮЗ-ийн орлогч дарга С.Бямбацогт удирдан Ажлын албатай хамтран зохион байгуулсан. Тус | Дараагийн хурлыг 11 дүгээр сард зохион байгуулах<br><br>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хурлаар Үндэсний зөвлөлийн гишүүдэд 2023 оны Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Мөн “Урьтаж ухаар” аяны талаар танилцуулж, хийх ажлын төлөвлөгөөг танилцуулсан. 50% | сангийн холбогдох байгууллагууд /ЭМЯ, ЗТХЯ, ТЦА, ТатЕГ, ХНХЯ ХНХСҮСИ, АТҮТ, ЗТХТ, ЦЕГ БХТ, АЖДХ, бүртгэл, мэдээллийн сангийнхаа талаар танилцуулга хийх |
| 1.12. | ЗХАБ-ыг хангах 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулах | ЗХАБҮЗ АА | ЗТХЯ СХГ | ЗХАБ-ыг хангах 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 55.3 %-ийн биелэлттэй үнэлэгдсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлөөр болон ЗХАБ-ын Үндэсний зөвлөлөөр танилцуулсан. УИХ-ын ХЗБХ-нд танилцуулахаар бэлтгэж байна. 100% | УИХ, ЗГ-т танилцуулах, тайлагнах |
| 1.13. | ЗХАБ-ыг хангах 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэх | ЗХАБҮЗ АА | ЗТХЯ СХГ | ЗХАБ-ыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэрэгжилийн явц байдлыг 2023.09.15-ны байдлаар гаргаад байна. 50% | Төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах |
| 1.14. | Монгол Улсын Засгийн газар, Улсын Их хуралд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайлангийн хэрэгжилтийг танилцуулах | ЗХАБҮЗ АА | | Засгийн газрын хуралд танилцуулах бэлтгэл ажлыг хангаж байна. 30% | Яамдуудаас санал авах албан бичиг явуулах |
| **2.** | **Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх холбогдох сургалтын үйл ажиллагааг сайжруулах, сургалтын материалуудыг бэлтгэх, сургалтын хөтөлбөрүүдэд энэ чиглэлийн асуудлуудыг тусгах, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах** | | | | |
| 2.1. | “Урьтаж Ухаар” сэдэвт ЗХАБ-ыг хангах 7 хоногийн аянг | ЗХАБҮЗ АА, ДЭМБ, | | НҮБ болон ДЭМБ-аас жил бүрийн 05 дугаар сард Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 7 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулах | НТГ, ТЦА | | хоногийн сэдэвт аяныг зохион байгуулдаг уламжлалтай. Монгол Улсын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын 7 хоног”-ийг 2023 оны 05 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд “Урьтаж Ухаар” сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүлж, ДЭМБ-ын өгөгдсөн зөвлөмжийн дагуу явган зорчигчид, унадаг дугуй, нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан.<br>“Урьтаж Ухаар” сэдвэт ЗХАБ-ыг хангах 7 хоногийн аянг зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар ДЭМБ-д мэдээлж, 2023.08.09-ний 12/07 албан бичиг явуулсан. 100% | |
| 2.2. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон сургуулийн өмнөх насны хүүхдэд замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал олгох сургалтын цагийг СӨБ болон ЕБС-иудын хичээлийн хөтөлбөрт тусгах | БШУЯ, ЗХАБҮЗ АА | | **I.** БШУС-ын сайдын 2019 оны А/494 тоот тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр"-т хүүхдийн хөгжлийн 3 түвшин тус бүрт замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал, чадварыг сургалтын чиглэл бүрд тусгасан. Нийгэмшихүйн хөгжил сургалтын чиглэлд Дүрэм журмыг ойлгох, Хөдөлгөөн, эрүүл мэнд сургалтын чиглэлд: Гэмтэхээс болгоомжлох, өвчлөхөөс сэргийлэх мөрдөх сурах зэрэг чадварыг эзэмшүүлэх агуулгыг бүлэг тус бүрээр хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн, сургалтын төлөвлөгөөнд тусган, цэцэрлэгийн өдрийн дэглэмийн сургалт, үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлж байна. Жишээ нь: Бага бүлэгт "Ногоон | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлын хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдэд замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал олгох сургалтын агуулгыг сургалтын чиглэл бүрт интеграци хийх.<br>Эцэг эх асран хамгаалагчаар дамжуулан сургуулийн өмнөх насны хүүхдэд замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал олгох нөлөөллийн ажил зохион байгуулах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | гэрэл, цагаан шугам" анхан шатны ойлголт өгөх, Дунд бүлэгт "Машинд суухдаа бүсээ бүслэх, Цагаан шугам явган хүний гарц, гэрлэн дохионы ялгааг таних, мэдэх, Ахлах бүлэгт гэрлэн дохионы үүрэг ач холбогдолыг мэдэх, цагаан шугамаар зорчих, бусдаас тусламж хүсэх, бусдад туслах, Бэлтгэл бүлэгт замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадалтай болж, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хамгаалахад хувь нэмрээ оруулах чадварт суралцсан байна.<br>БШУС-ын сайдын 2018 оны А/181 тоот тушаалаар "Аюулгүй амьдар ухааны хөтөлбөр" батлагдаж Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэжмсэн нэмэлт хөтөлбөрөөр хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь а) Орчны аюулгүй байдал б) Гамшиг, осол, аюулт үзэгдэл гэсэн ерөнхий 2 агуулгын хүрээнд сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж явуулж байна. "Орчны аюулгүй байдал" ерөнхий агуулгын "Нийгмийн орчны аюулгүй байдал" гэсэн дэд агуулгад "Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ногоон гэрэл, цагаан шугам үүрэг ач холбогдолыг мэдэх, суудлын бүс бүслэх дадалтай болох, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хамгаалахад хувь нэмрээ оруулах, бусдаас тусламж хүсэх, бусдад туслах чадвар эзэмшинэ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэхдээ хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн тодорхой давтамжтайгаар, тоглоомын үйл ажиллагаагаар дамжуулан чадвар эзэмшүүлдэг.<br>**II.** Ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх “Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр”-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар батлуулж, 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.<br>Уг хөтөлбөрийг сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хэрэгжүүлэх бөгөөд ахуйн орчны аюулгүй байдал, нийгмийн орчны аюулгүй байдал, байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл гэсэн 4 бүлэг агуулгын хүрээнд орж байна. Үүнээс нийгмийн орчны аюулгүй байдал бүлэгт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг судлах, замын хөдөлгөөнд оролцох үед явган зорчигчийн үүргийг мэдэх, анхаарал болгоомжтой оролцох, цаг агаарын өөрчлөлтөөс болж үүсэх зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, явган алхах үед болон ердийн хөсөг, унадаг дугуйгаар аюулгүй зорчихыг эрхэмлэх, бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчихдоо зорчигчийн дүрэм, журмыг баримтлах, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ /мэдээлэх, хориглох, заах, анхааруулах, дараалал тогтоох/-г ялган таних, найз нөхөд, дүү нартаа тайлбарлах, жолоочийн үүрэг хариуцлагыг ойлгох, зам тээврийн осолд хариуцлага, хохирлыг барагдуулах шаардлага гардгийг мэдэх зэрэг агуулгыг тусган, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид судалж байна. 100% | |
| 2.3. | Сургуулийн өмнөх боловсрол болон бага, суурь, бүрэн дунд сургалтын хөтөлбөрт тусгагдсан замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгохтой холбоотой агуулгад шинжилгээ хийх, тусгагдсан агуулгыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | БШУЯ, ЗХАБҮЗ АА | | Замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгохтой холбоотой агуулга нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан. Цэцэрлэг, сургуулийн хүүхдээр дамжуулан эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах, насанд хүрэгчид биечлэн үзүүлж, үлгэр дууриалал үзүүлэхэд анхаарах, замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх агуулгыг хүүхдэд эзэмшүүлэхэд сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, цахимжуулах, бодит орчинтой танилцах, багшийн арга зүйг сайжруулахад, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. 100% | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах, сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай тогтмол хэрэгжүүлэх |
| 2.4. | Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх тогтолцоог шинэчлэх, холбогдох хууль, дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах | ХЗДХЯ, ЗХАБҮЗ АА | ЗТХЯ, ЭМЯ, БШУЯ, ХНХЯ, ХНХСҮСИ, АТҮТ, ЦЕГ БХТ, ТЦА, | ЗТХС/БШУС-ын хамтарсан 2023.04.14-ний А/116/ А/161 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2023.05.02, 2023.06.05-ны өдрүүдэд тус тус хуралдаж, хийх ажлын төлөвлөгөөг баталж, Жолооны сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа, танхим, | Холбогдох эрх зүйн бичиг баримтын төслийг эцэслэн боловсруулах, батлуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | автодром нөхцөл байдалтай танилцсан. 70% | |
| 2.5. | “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх журам”, “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг, “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн үнэмлэхний загвар”-ыг шинэчлэн батлуулах | ЗТХЯ, БШУЯ, ХНХЯ | ХЗДХЯ, ЭМЯ, ХНХЯ ХНХСҮСИ , АТҮТ, ЦЕГ БХТ, ТЦА | Журмын төслүүдийг боловсруулж, холбогдох байгууллагууд, ажлын хэсгийн гишүүдээс санал авч байна. 70% | Журмуудын төслийг эцэслэн боловсруулах, батлуулах |
| 2.6. | Авто замын дагуух үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын ажилчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг чадварыг эзэмшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | ЭМЯ, ЗХАБҮЗ АА, МУЗН | | АЗдҮЦ ТББ-тай уулзсан. ЭМЯ-тай ярьж, Автозамын дагуух үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн арга хэмжээн дээр сургалт зохион байгуулахаар тохирсон. 50% | Нэгдсэн арга хэмжээн дээр сургалт явуулах |
| 2.7. | Ногоон гэрэл, цагаан шугам” ба “Замын хөдөлгөөний цагаан толгой” арга хэмжээний удирдамжийг боловсруулах, батлуулах | БШУЯ, ТЦА | ЗХАБҮЗ АА | Хүүхдийг зам тээврийн осолд өртөж амь нас эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэх, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд зохион байгуулах “Замын хөдөлгөөний цагаан толгой-2023” тэмцээнийг хуваарийн дагуу энэ оны 05 дугаар сарын 01-нээс 20-ны өдрийн хооронд улсын хэмжээнд амжилттай зохион байгуулж Орон нутагт **139** цэцэрлэгийг **1356** хүүхэд, | Цаг үеийн шаардлагаар арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | **278** багш, **278** эцэг эх, Нийслэлд **90** цэцэрлэгийн **1130** хүүхэд, **186** багш, **186** эцэг эх оролцож шилдгүүдээ шалгаруулан замын хөдөлгөөний дүрмийг сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд сурталчлах зам тээврийн осол хэрэгт бага насны хүүхдийг өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд олон нийтэд сурталчилж, тус тэмцээнийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас **21** нэгж зохион байгуулж улсын хэмжээнд нийт **229** цэцэрлэгийн **2486** хүүхэд, **464** багш, **464**, эцэг эх оролцсон байна. 100% | |
| 2.8. | Авто замын зорчих хэсэгтэй ойр буюу эрсдэлтэй бүсэд байрлаж буй сургуулийн судалгааг ТЦА-тай хамтран зохион байгуулах | БШУЯ, ТЦА | ЗХАБҮЗ АА | Зорчих хэсэгтэй ойр байрлалтай ерөнхий боловсролын сургууль орчмын эрсдэлийн үнэлгээг гаргах ажлыг Тээврийн цагдаагийн албанаас энэ оны нэгдүгээр улиралд зохион байгуулсан. Дээрх ажлын хүрээнд орон нутагт 53, Улаанбаатар хотод 65 ерөнхий боловсролын сургуулийн эрсдэлийн үнэлгээг гаргасан. 100% | Тайлан мэдээллийг ирүүлэх |
| 2.9. | Ерөнхий боловсролын бүх сургууль, бага, дунд, ахлах ангийн суралцагчдыг хамруулан замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, сургуулийн орчинд болон нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үеийн эрсдлээс | БШУЯ, Аймаг, нийслэлийн ЗД, ТЦА | ЗХАБҮЗ АА | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Эрүүл мэндийн яамтай хамтран зохион байгуулсан “Урьтаж ухаар” арга хэмжээний хүрээнд Тээврийн цагдаагийн албанаас ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Унадаг дугуй, мопед, мотоциклоор замын хөдөлгөөнд оролцоход анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан. 100% | Цаг үеийн шаардлагаар арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх зэрэг мэдлэг, ойлголт олгох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах | | | | |
| **3. Тээврийн дэд бүтэц болон тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах** | | | | | |
| 3.1. | Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр баригдаж байгаа Улаанбаатар-Дархан, Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замд хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ хийх | ЗХАБҮЗ АА | | Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/38 тоот тушаалаар Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр баригдаж байгаа Улаанбаатар-Дархан, Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замд хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг 2 сарын хугацаанд ажиллаж үнэлгээ хийж дүгнэлт гаргасан. Тус ажлын хэсэг нь ЗТХЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар оруулж танилцуулсан. 100% | |
| 3.2. | Олон улсын болон улсын чанартай авто зам дагууд хурд хянах камерийг суурилуулах /39 камер/ | ТЦА | | ХЗДХЯ-ны харьяалах асуудлын хүрээнд 2024 оны Улсын төсөвт 39 тэрбум төгрөгийн хөрөнгө тусгуулахаар санал оруулсан. 70% | 2024 оны Улсын төсөвт бүрэн тусгуулах |
| 3.3. | “Дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай | ЗТХЯ, ЗХАБҮЗ АА | АТҮТ, | Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. МУ-ын Засгийн газраас хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Монгол | Конвенцийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | болон эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр (1958 оны)”-ийн хэрэгжилтийг хангах, холбогдох ажлуудыг зохион байгуулах | | | Улсын Их хурлаас “Хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр баталсан. 70% | |
| 3.4. | Олон улс, улсын чанартай авто замаар даац хэтрүүлэн тээвэрлэлт хийх зөрчлийг багасгах, хяналт шалгалтыг хийх, эрх зүйн орчныг сайжруулах | АЗБЗГ, ЗХАБҮЗ АА | | 2023 оны эхний хагас жилд нийт пүүлсэн тээврийн хэрэгслийн тоо-152145, стандарт шаардлагад нийцсэн ачаатай хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл-136216, даац хэтрүүлсэн тээврийн хэрэгсэл-10062, зөрчил арилган хөдөлгөөнд оролцсон тээврийн хэрэгсэл-2133, торгуулийн арга хэмжээ - 1013, эхлэлийн цэг рүү буцаасан тээврийн хэрэгсэл-1511, сануулах арга хэмжээ - 771, зугтсан – 439 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн.<br>“Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн шаардлага. MNS 6278:2020 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Гашуунсухайт боомтын чиглэлд нүүрс тээврийн үйлчилгээ эрхлэгч компаниудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан бөгөөд үүний дагуу “Түмэннаст тээвэрчдийн зөвлөл” холбоотой 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Тус холбооны 23/018 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Уг саналыг | Холбогдох баримт бичгийн төслийг боловсруулж дусгах, батлуулах<br>Хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | стандартын төсөлд тусгасан бөгөөд стандартын төслийн боловсруулалт дуусах шатанд байна.<br>ЗГ-ын 2023.06.07-ны өдрийн 222 дугаар тогтоолын 2-р хавсралтаар “Олон улсын, улсыын чанартай автозам, замын байгууламж ашиглан зөвшөөрөгдөөх дээд хэмжээнээс хэтэрсэн задрах боломжгүй ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ”-г баталсан.70% | |
| 3.5. | “Замын хөдөлгөөний автомат удирдлагын техник хэрэгсэл хэрэглэх” техникийн шаардлага стандарт боловсруулах | ЗТХЯ, ЗХАБҮЗ АА | АТБЗГ, АТҮТ, АЖДХ, | Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID)-г тээврийн хэрэгсэлд бүртгэх үйл ажиллагаанд ашиглах програм хангамжийг хөгжүүлэх ажлын даалгавар, Зам, тээврийн нэгдсэн системийн туршилтын систем буюу демо хувилбар системийн ажлын даалгавар, зам, тээврийн нэгдсэн системийн ерөнхий архитектур, тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийг шинэчлэн боловсруулах ажлын даалгавар, ТАЦ цахимжуулах техник хэрэгсэл худалдан авах, интернет холболт хийх шилэн кабель татах ажлын даалгавар зэргийг боловсруулаад байна. Мөн холбогдох зааварчилгаа, журмыг АТБХЗГ боловсруулан батлуулсан ба Ажлын хэсэг Улаанбаатар хотын автотээврийн хэрэгсэд RFID шошго байршуулах 100 цэгийг батлав.RFID шошгоны дугаарлалтыг олон улсын GS1 стандартын дагуу дугаарлахаар Монгол дахь | Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID)-г нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | төлөөлөгч "GS1 Монгол" ТББ-тай гэрээ байгуулж гишүүн хэрэглэгчээр бүртгүүлж код авав. Нийслэлийн төсвийн 3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр эхний ээлжинд 442 мянган тээврийн хэрэгсэлд RFID шошго суурилуулах ажлын гүйцэтгэгчтэй Нийслэлийн ЗДТГ гэрээ байгуулсан. Дээрх техникийн болон ажлын даалгавруудын дагуу худалдан авах ажиллагааг 2023 оны 6 болон 7 дугаар сард зохион байгуулахаар Үнэлгээний хороо байгуулан ажиллаж байна. 70% | |
| **4. Зам тээврийн осол, түүний хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах** | | | | | |
| 4.1. | Замын хөдөлгөөний аюулгүй байдал–аюулгүй байдлын удирдлагыг нэвтрүүлэх сайн туршлага MNS ISO39002:2022 стандартыг батлуулах, ажлыг зохион байгуулах | ЗХАБҮЗ АА, АТҮТ | ЗТХЯ АТБЗГ | Стандартыг орчуулж бэлэн болгосон. 70% | Орчуулгыг хянаж, санал авах, батлуулах |
| 4.2. | Замын хөдөлгөөний болон тээвэрлэлтийн аюулгүй байдалд хяналт тавьж буй замын цагдаа, автотээврийн хяналтын улсын байцаагч нарт эрх зүйн мэдлэг олгохоос гадна ёс зүйн хамтарсан сургалтыг жилд 2 | ТЦА, АТҮТ | ЗХАБҮЗ АА | Нийслэлийн Прокурорын газраас АТҮТ ТӨҮГ-ын эрх бүхий албан тушаалтнуудаас зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад анхаарах асуудлаар 2023 оны 05 сарын 24-ний өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтад нийслэлийн Автотээврийн болон тус үйлдвэрийн газрын нийт 32 эрх бүхий албан тушаалтан хамрагдсан. 70% | “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 4978:2017 улсын стандартын шинэчлэлт болон “Аюултай ачаа тээврийн автомашин /чиргүүл/-ыг шалгах хяналтын хуудас, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS *4598*:2020 стандартын өөрчлөлт сэдвээр 2023 оны 10 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | удаа зохион байгуулах | | | | дугаар сард сургалт зохион байгуулна. |
| 4.3. | Ноцтой, хүнд гэмтлийн үед нисдэг тэрэг, бага оврын агаарын хөлөг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны зохицуулалт, шаардагдах санхүүжилтийн тооцоо зэрэг холбогдох судалгаа хийх | ЭМЯ | ЗХАБҮЗ АА, ОБЕГ, ЭМДЕГ, | Осол аваарт өртөгсөд болон хүнд өвчтэй хүнийг нисдэг тэргээр зөөвөрлөх харилцааг зохицуулах журам боловсруулах талаар ЭМЯ, ОБЕГ, ЭМДЕГ-тай ярьж байна. 30% | Журмын төслийг боловсруулах, батлуулах |
| **5.** | **Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар сурталчлах, таниулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр санамж, зөвлөмж нийтлэх, нэвтрүүлэх** | | | | |
| 5.1. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон нийтийг хамарсан компанит ажлыг зохион байгуулах | ТЦА, АЖДХ, МҮОНРТ, ЗХАБҮЗ АА | | НҮБ болон ДЭМБ-аас жил бүрийн 05 дугаар сард Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 7 хоногийн сэдэвт аяныг зохион байгуулдаг уламжлалтай. Монгол Улсын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын 7 хоног”-ийг 2023 оны 05 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд “Урьтаж Ухаар” сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүлж, ДЭМБ-ын өгөгдсөн зөвлөмжийн дагуу явган зорчигчид, унадаг дугуй, нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс төлөвлөгөөнд нийт 17 арга хэмжээг тусган ажиллаж биелэлтийг тооцлоо Аяны арга хэмжээг нийтэд зарлах Хэвлэлийн хурлыг Зам, тээврийн хөгжлийн яамны хурлын танхимд 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 10:30 цагт зохион байгуулж ЗТХЯ | Хэвлэл мэдээллийн байгууллагаас МҮОНРТ, ETV, Монгол HD, TV-9, Tenger.mn телевизүүд, МҮОНРадио хурд агентлаг, News.mn, Arslan.mn, Isee.mn, mand.mn, Ikon.mn, Mpress.mn, Asu.mn зэрэг сайтуудад хүрэлцэн ирж мэдээлэл хүргэлээ. 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр NTV телевизээр явган зорчигч, унадаг дугуй, суррон, мопед, мотоцикл, нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчийн аюулгүй байдлын талаар “Өөр өнцөг” хэлэлцүүлэгт ЗТХЯ, ТЦА, Тээврийн прокурор, Нийтийн тээврийн газрын холбогдох төлөөллүүд оролцлоо. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | /ЗХАБҮЗ/-ийн ажлын алба, Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн нийтийн тээврийн газрууд хамтран зохион байгуулав. 100% | Цаг үеийн шаардлагаар арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах |
| | | | | 66,87% | |

---o0o---